



АРДЧИЛСАН НАМ

2001 оны 3 дугаар сарын 25-ны өдөр

№08

Улаанбаатар хот

НАМЫН ДАРГЫН ТУШААЛ

Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр
дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг
батламжлах тухай

Ардчилсан намын Үндэсний Зөвлөлдөх Хорооны Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний Зөвлөлдөх Хорооны журмын 9-ийн 2-ыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Раднаасүмбэрэлийн Гончигдоржийн мөрийн хөтөлбөрийг батламжилсугай.



НАМЫН ДАРГА

Д.ДОРЛИГЖАВ

25

**ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛДӨХ ХОРООНЫ
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРОО**

2001 оны 03 сарын 24 өдөр


№ 2

Улаанбаатар хот

Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны
Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлт

Үндэсний зөвлөлдөх хорооны Төрийн байгуулалтын байнгын хорооны 2001 оны 03-р сарын 24-ний өдрийн хуралдаанаар Монгол улсын Ерөнхийлөгчийн 2001 оны сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Р.Гончигдоржийн мөрийн хөтөлбөрийг хэлэлцээд дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Үндэсний зөвлөлдөх хорооны анхдугаар хуралдаанаас сайшаасан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүд, байнгын хороодын дарга нарын гаргасан саналыг тусган ажлын хэсгээс эцэслэн боловсруулсан хөтөлбөрийг Төрийн байгуулалтын байнгын хороо дэмжиж байна.
2. Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг батламжлуулахаар намын даргад хүргүүлэх нь зүйтэй гэж үзэв.

БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА  С. БАТМӨНХ

28

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД
АРДЧИЛСАН НАМААС НЭР ДЭВШИГЧ УЛАМОРГИХ ОВГИЙН
РАДНААСҮМБЭРЭЛИЙН ГОНЧИГДОРЖИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**ТЭНЦВЭРТЭЙ ТӨР
ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

Монголын ард түмэн зуун зууны турш ээлж дараалсан түүхийн огцом нугачааг асар их зориг тэвчээр, хүч хөдөлмөрөөр гэтэлж, туурга тусгаар улсынхаа голомтыг сэргээн бадрааж хүн төрөлхтөний нийтлэг үнэлэмжээр төр засгаа төвхнүүлэн ахуй амьдралаа тохинуулж эрх чөлөөт хүний эрхэм чадал, бүтээлч хөдөлмөрөөр хөгжил дэвшлийн замд орох үүд хаалгыг нээлээ.

Өнгөрсөн 10 жилд зориг шулуудан сонгосон Ардчилсан шинэ замнал дээр тууштай зогсож, улам бүр даяарчлагдаж байгаа дэлхий нийттэй хөл нийлүүлэн улс үндэстнийхээ эв нэгдлийг бэхжүүлж, хүчээ нэгтгэн хөгжил дэвшлийг зорих нь монгол түмний эрхэм дээд эрх ашиг болж байна.

Бидний одоогийн байдлыг эдүгээ болон хойч үеийнхний эрх ашиг, дэлхий ертөнцийн чиг хандлагын талаас авч үзвэл ахиц дэвшлийн зэрэгцээ учирч буй бэрхшээл, шийдээгүй асуудал цөөнгүй байна.

Эдүгээ монгол оронд төрийн бүх эрх мэдэл улс төрийн нэг хүчний гарт хумигдаж, төрийн тэнцвэр алдагдан, эрх баригчид ард түмэндээ өгсөн амлалт, мөрийн хөтөлбөрөөсөө ухрах, ардчиллын дэлхий нийтийн түгээмэл зарчмууд алдагдах байдал гарч эхэллээ. Хуучин тогтолцооны мухардал, шилжилтийн үеийн хямрал доройтлоос үүссэн ядуурал, ажилгүйдэл, боловсролгүйдэл зэрэг олон хурц асуудал шийдэгдээгүй байна.

Ардчилсан тогтолцооны туйлын зорилго нь улс орны хөгжил цэцэглэл, хүн ардын сайн сайхан амьдралын баталгааг хангахад оршдог. Ардчиллын үнэт зүйлсийг хамгаалан бэхжүүлж, өөрийн орны орчин нөхцөл, соёл, зан суртахууны өвд нийцсэн тогтолцоог төлөвшүүлж үндэснийхээ уужуу тайван ухаан бодол, эв нэгдлийн хүчээр тохиолдож буй бэрхшээлийг гэтлэн давахад төрийн тэргүүн улс үндэснийхээ өмнө тулгарч буй зорилтыг шинэ, өөдрөг үзэл санаагаар харж, шийдвэртэй, зоримог бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлж эхлэх нь өнөөгийн нийгмийн захиалга хэмээн үзэж энэхүү мөрийн хөтөлбөрөө түмэн олондоо толилуулж байна.

Нэг.Төрийн тэргүүний бүрэн

эрхийн хүрээнд хэрэгжүүлэх зорилтууд

Монгол улсын Ерөнхийлөгчид Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг эх орон ард түмнийхээ өмнө хүлээсэн өндөр хариуцлагын түвшинд иргэддээ ил тод

байдлаар хэрэгжүүлж, манай орны улс төр, эдийн засаг, нийгмийн тулгамдсан асуудлууд дотроос дараах асуудлыг шийдвэрлэх нь тэргүүн зэргийн ач холбогдолтой хэмээн үзнэ. Үүнд:

а) Улс төр, төрийн байгуулалтын хүрээнд

1. Ард түмний сонгож байгуулсан төрийн бүх салаа мөчир сонгогчиддоо өгсөн амлалтаа гуйвалтгүй биелүүлж, ардчиллын баталгаа, үндэсний аюулгүй байдал, хөгжил дэвшлийн зорилтыг бодиттойгоор хариуцах, сонгогчдын итгэл найдварыг дээдлэх зарчмыг хатуу баримтлахад төрийн тэргүүнд Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг гүйцэд хэрэгжүүлж үүнд чиглэсэн УИХ, Засгийн газрын үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
2. Төрийн бүх шатны албадыг үндсэн хуулийн зарчим дээр нэгдмэл бодлого хэрэгжүүлэхэд чиглүүлэн жолоодож, төр хуулиа дээдлэж, нийгэмдээ шударга тэгш үйлчлэх зарчмыг чанд баримтална. Бизнесийн тодорхой бүлэглэл, улс төрийн аль нэг намын эрх ашгийг улс үндэснийхээ эрх ашгаас дээгүүр тавьдаг буруу хандлагыг эцэс болгоно.
3. Төрийн албад, албан хаагчдыг улс төрийн хүчнүүдийн сөргөлдөөнөөс ангид байлгаж, улс гэрийнхээ нэгдмэл, нийтлэг эрх ашгийг дээдэлсэн үндэсний эв нэгдлийн гол цөм болох нөхцөлийг бүрдүүлнэ. Үндсэн хуулийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа улс төрийн намуудтай бүрэн эрхийн хүрээнд бүтээлчээр хамтран ажиллана.
4. Улс орноо шинэ зууны гараан дээр түргэн хувьсч буй дэлхий нийтийн орчин нөхцөлд нийцүүлэн бүс нутгийнхаа хөгжил цэцэглэл, аюулгүй, тогтвортой байдлын тогтолцоонд баттай байр суурь эзлүүлэх төрийн цогц бодлогыг өөрийн орны экологи, нөөц боломж, газар зүйн байршил, гадаад орчинд зохицуулан үндэсний зөвшлийн түвшинд боловсруулан баталгаажуулж чанд баримтална.
5. Улс орны тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлын баталгааг бүх талаар бэхжүүлэн, байгаль экологи, эдийн засаг, нийгмийн аюулгүй байдлын тулгамдсан асуудлуудыг үндэсний аюулгүй байдлын зөвлөл, төрийн тэргүүний анхаарлын төвд байлгаж шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
6. Монгол улсынхаа эрх зүйн орчныг нийгмийн ардчиллын баталгааг улам бэхжүүлж, шударга ёс, хүмүүнлэг харилцаа, хөгжил дэвшлийн орон зай бүрдүүлсэн иргэний нийгмийн зорилтод нийцүүлэн төгөлдөржүүлж, сайн засаглалын зарчмуудыг хэрэгжүүлэхийг зорино. Төр өөрөө хуулийг дээдлэх зарчмыг тууштай хэрэгжүүлснээр төрийн хууль хэлбэрэлтгүй хэрэгжих нөхцөлийг бүрдүүлнэ. Үндсэн хуулийн байгуулал хоорондын эрх мэдэл булаацалдсан байдлыг үндсэн хуулийн хүрээнд эцэс болгоно. Авилгал, хээл хахуултай тэмцэх үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлнэ.

30 54

Шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, гэмт хэргийн гаралтыг бодитойгоор бууруулахад хуулийн байгууллагууд, нэн ялангуяа шүүхийн үүргийг улам бүр дээшлүүлэн хуулийн байгууллагын тогтолцоо, боловсон хүчний бодлогод шинэчлэлт хийж томилгооны хараат байдлыг арилгаж ажилтнуудын амьдралын баталгааг сайжруулна. Хууль ёс, хүний эрх, эрх чөлөөний баталгаа болох шүүх эрх мэдлийн бие даасан хараат бус байдал, ил тод ажиллагааг хангаж, шүүхийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцдог байгууллагуудад зориулах төсөв, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж тэдгээрийн боловсон хүчин, сургалт, техникжүүлэлт, менежментийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх арга хэмжээ авна.

8. Төрийн тогтолцоог улам боловсронгуй болгож, төрийн үйлчилгээг олон түмэнд тэгш, шуурхай, хямд төсөр хүргэх зарчмаар өөрчлөн байгуулна. Төрийн төсвийн дарамтыг бууруулж, төрийн албан хаагчдын амьдралын баталгааг дээшлүүлэх арга хэмжээ авна.

9. Цэргийн шинэтгэлийн бодлогыг тууштай хэрэгжүүлж, зэвсэгт хүчний болон цэргийн цол хэргэмийн нэр хүндийг өргөж, хангалтыг сайжруулан орон нутгийн өөрөө хамгаалах цэргийн сургалт бэлтгэл, хил хамгаалалтын харилцан холбоо бүхий тогтолцоог бүрдүүлж зэвсэгт хүчний анги салбаруудыг мэргэжлийн бүрэлдэхүүнтэй зохион байгуулалтад нэн даруй ээлж дараалан оруулж, даргалах болон бусад бие бүрэлдүүнийг орчин үеийн зэвсэгт хүчинтэй хамтран ажиллах бүрэн бэлтгэлтэй болгож цэргийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

10. Төрийн гадаад бодлогын уламжлалт чанарыг хадгалахын зэрэгцээ дэлхий нийтийн даяарчлалт, нөлөө бүхий хүчин зүйлсийн одоогийн бүтэц, нээлттэй харилцааны зарчмуудыг үндэс болгон улс орныхоо язгуур эрх ашиг, хөгжлийн зорилтыг бүс нутгийн нийтлэг эрх ашгийн хүрээнд нийцүүлэн идэвхжүүлнэ.

б) Эдийн засгийн хүрээнд

1. Төрийн эдийн засгийн бодлогыг улам бүр хүмүүнлэг чиг баримжаатай, хөгжлийг дэмжин тэтгэх чадвартай болгож олон улсын нээлттэй зах зээл, өндөр хөгжилтэй технологи, мэдээллийн чөлөөт орны давуу талыг өөрийн эрх ашигт оновчтой зохицуулсан үндэсний чөлөөт эдийн засгийн бүтцийг төлөвшүүлэхийг төрийн бодлогын үндэс гэж үзнэ.

2. Хүн амын зах зээлийн хангамжийн гол эх үүсвэр, олон мянган айл өрхийн амьжиргааны баталгаа, эх сурвалж болсон жижиг, дунд худалдаачид, аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаа өнөөгийн үнэ, татвар, мөнгөний буруу бодлого, хүнд суртлын элдэв дарамтаас үүдэн туйлын хүнд нөхцөлд орсныг анхааралдаа авч тэдний бизнесийн орчинг сайжруулж, эрх зүй, санхүү, мөнгөний бодлогоор тууштай дэмжихэд төрийн бодлогыг чиглүүлнэ.

3.Өндөр үр ашигтай, үндэсний хэмжээний аж ахуйн цогцолборуудыг хувийн өмчийн хүрээнд хөгжүүлэхэд таатай нөхцөл бүрдүүлнэ.

4.Өөрийн орны зах зээлийг шударга бус өрсөлдөөнөөс хамгаалах арга хэмжээ авч үндэсний үйлдвэрлэлийг бүх талаар дэмжинэ.

5.Төрөөс баримтлах хөдөөгийн бодлогыг хөдөө нутгийн хүн ардын аж амьдралыг байгалийн болон бусад хүчин зүйлсийн улмаас тохиолдох эрсдэлээс бололцоотой бүх аргаар хамгаалж сүүлийн жилүүдэд ган зуд, малын өвчний улмаас учирсан хохирлыг нөхөхөд нь тусалж хот хөдөөгийн эдийн засгийн харилцааг тэнцвэржүүлэн, ахуйн цахилгаанжуулалт, холбоожуулалт, мэдээллийн үйлчилгээг өргөн дэлгэрүүлэхэд чиглүүлнэ.

6. Малчдыг аж ахуй эрхлэн зах зээлийн харилцаанд бие дааж орох эрх зүйн орчинг бүрдүүлнэ. Малчдын дунд сайн дураараа хорших, зээл хадгаламжийн болон бэлтгэлийн хоршоо, банкны бус санхүүгийн байгууллага байгуулах ажлыг төрийн зүгээс дэмжсэн бодлого хэрэгжүүлнэ. Мал аж ахуйг даатгалд хамруулах нөхцөлд даатгалын тодорхой хувийг төрөөс хариуцах бодлого баримтална.

7.Газар тариалан эрхлэгчдийн газрын эрхийн баталгааг хувьчлах болон бусад арга замаар хангана.

8.Өөрийн эдийн засгийг бодитой дэмжих чадвартай, үр ашигтай, банк санхүүгийн тогтолцоо, зах зээлийн дэд бүтцийг хувийн хэвшилд тулгуурлан хөгжүүлэхийг эрхэмлэнэ.

9.Гадаадын зээл тусламжийг өөрийн орны үндэсний аюулгүй байдал болон хөгжлийн үзэл баримтлалтай нягт уялдуулан төр, олон нийтийн ил тод хяналтын дор үр ашигтай зарцуулах бодлого баримтална.

в) Нийгмийн хүрээнд

1.Боловсрол, шинжлэх ухааны салбарын тэргүүлэх байр суурийг бодитой хангах нь нийгмийн хөгжлийн түлхүүр асуудал мөн гэж үзэж, иргэний боловсролын тогтолцоог орчин цагийн өндөр мэдлэг, амьдралаа тэтгэх чадвар, эх орон, үндэснийхээ өв соёлоор бахархах, өөдрөг сэтгэлийн тэнхээтэй хойч үеийг бэлтгэх чиглэлээр хөгжүүлэхийг эрхэмлэнэ.

2.Шинжлэх ухаан, судалгаа, туршилт, боловсруулалтын үндэсний тогтолцоог төр, хувийн хэвшлийн хамтын оролцооны үндсэн дээр хөгжүүлж, олон улсын зах зээлд өрсөлдөх найдвар бүхий чиглэлүүдээр үндэсний судалгаа, боловсруулалтын төв (технопарк) -үүдийг төрийн зонхилох оролцоотойгоор байгуулж дэмжинэ.

3.Ард түмнийхээ аж амьдралыг дээшлүүлж, нийгмийн эмзэг бүлгийн хамгааллыг сайжруулахад төр олон нийтийн байгууллагын хүчин чармайлтыг хослуулан, өнчин ядуу хүүхэд, өндөр настан, тахир дутуу иргэдийн амьдралын наад захын баталгааг төрөөс бүрдүүлэх бодлого явуулна.

32 46
4. Үндэснийхээ түүх соёлын өвийг хамгаалах, нийтийн хүртээл болгож баяжуулан хөгжүүлэх төрийн бодлогыг эрчимжүүлж, соёл урлагийн салбарын зохион байгуулалт, материаллаг баазыг бэхжүүлэх, боловсон хүчин бэлтгэхэд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлнэ.

5. Үндэсний шашин соёлын арвин баялаг мэдээллийн чөлөөт орчинг дэлхий нийтийн түгээмэл үнэт зүйлсд зохируулан хүн ардынхаа ариун нандин зан суртахуун, ёс заншлыг хөгжүүлэх, сэтгэл санаа, итгэл үнэмшлийг шинэ сонголтын замд нийцүүлэн төлөвшүүлэхэд төрийн тэргүүний нөлөөг бүрэн ашиглана.

6. Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээг чанаржуулж, иргэдийн амь нас, хойч үеийн эрүүл мэндэд хор хохирол учруулж байгаа өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хязгаарлан бууруулахыг төрийн бодлогын нэн тэргүүний зорилт гэж үзнэ.

7. Хөдөлмөрийн хөлсний болон амьжиргааны доод хэмжээг мөнгөний ханш уналт, бараа, үйлчилгээний үнэ тарифын өсөлттэй уялдуулан жил бүр шинэчлэн тогтоож, цалин хөлс, бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг тогтвортой нэмэгдүүлж, хугацаанд нь олгуулах, хоцроосон тохиолдолд алдангийг хуулийн дагуу тооцож байх шударга зарчмыг хэрэгжүүлэхэд төрийн тэргүүний бүрэн эрхийг чиглүүлнэ.

8. Байгаль орчин, экологид нүүрлэж буй сөрөг үр дагаварыг сааруулах, цөлжилт, хөрсний эвдрэл, хот суурин газруудын орчны бохирдлыг бууруулах, ойн бүрхэвчийг хамгаалан сэргээх, усны нөөцийн хомсдолыг арилгах арга хэмжээг хойшлуулшгүй нэн чухал хэмээн үзэж, төрийн болон аж ахуй, олон нийтийн хүчин чармайлтыг нэгтгэн уялдуулна.

9. Олон түмэнд үнэн бодитой, бүрэн хангалттай мэдээллийг чөлөөтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэх нь нийгмийн ардчиллыг гүнзгийрүүлэх гол утвар нөхцөл гэж үзэж, төрийн эрхшээлд байгаа үндэсний радио телевизийг олон нийтийн чөлөөт мэдээллийн хэрэгслийн тогтолцоонд шилжүүлэн улс төрийн аль нэг хүчний хараа хяналтаас чөлөөлнө.

Хоёр. Ерөнхийлөгчийн санаачилга

Монгол улсын Ерөнхийлөгч төрийн тэргүүний хувьд Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ улс орныхоо шинэ сонголтыг баталгаажуулж, хөгжлийн эрч хүчийг нэмэхийн тулд үндэснийхээ бүтээлч оюун, эв нэгдэлд тулгуурлан гол зангилаа асуудлаар санаачилга гаргаж, төрийн бодлогод тусгахыг эрхэмлэнэ. Үүнд:

1. Тэргүүлэх эрдэмтдийн хүчийг нэгтгэн үндэсний хөгжлийн ойрын арваас хорин жилийн хөтөлбөр боловсруулж, өргөн хэлэлцүүлэг явуулан улс төр, олон нийтийн байгууллагуудын зөвшилд хүргэж хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

2. Өөрийн орны гол түүхий эдийн нөөц баялагийг технологийн өндөр түвшинд гүйцэд боловсруулж, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх чиглэлээр "мэдээлэл

технологи", "био технологи", "зэс", "ноос, ноолуур", "аялал жуулчлал" зэрэг зорилтот хөтөлбөрүүдийг Ерөнхийлөгчийн ивээл дор боловсруулан дэвшүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхэд дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхол татах таатай нөхцөл бүрдүүлнэ.

3.Эрчим хүчний хангамжийн асуудал нь хөгжлийн түлхүүр, улс орны аюулгүй байдлын нэгэн баталгаа, амьжиргааны гол хүчин зүйл гэж үзэн "эрчим хүч" хөтөлбөр боловсруулж, төрийн бодлого болгоно.

4.Гадаад орнуудад суугаа Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчдийн газруудын үйл ажиллагааг үнэлэхдээ эдийн засгийг өргөтгөх, монгол улсын иргэдийнхээ хууль ёсны эрх ашгийг хамгаалахад түлхүү анхаардаг болгох чиглэлээр бодлого боловсруулж хэрэгжүүлнэ.

5.Төр шашны харилцааны талаарх Үндсэн хуулийн заалтыг тууштай баримталж, төр нь шашнаа хүндэтгэх зарчимд нийцүүлэн жил бүрийн зуны эхэн сарын шинийн 15-ны Их дүйцэн өдрийг үндэснийхээ эв нэгдэл, ариун цагаан сэтгэл, сайн сайхны бэлгэдлийн зан үйл явуулдаг төрийн ёслолын өдөр болгоно.

6.Эрдэм шинжилгээ, зохион бүтээлт, оюуны туурвилын үнэтэй бүтээл гаргасан хүмүүст олгож буй төрийн соёрхол болон бусад төрийн дээд шагнал олгох журмыг шагнал нь нэр хүндтэй, эзнээ олсон байх зарчмаар шинэчилж дагалдах мөнгөн шагналыг үлэмж хэмжээгээр нэмэгдүүлнэ.

7.Улс орныхоо хөгжлийн тэргүүлэх чиглэлээр ажиллах нарийн мэргэжлийн үндэсний боловсон хүчин бэлтгэх төрийн хөтөлбөр боловсруулан баталгаажуулна. Тэргүүний оюутан, залуучуудад жил бүр олгодог Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг бий болгоно.

8.Үндэсний спортын төрлүүдэд өндөр амжилт гаргасан хүмүүст олгодог цол, хэргэмийг Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар олгодог болгоно.

9.Нийгмийн асуудлыг холч бодлоготой, зөв шийдэхэд чиглэсэн төрийн бодлогын хүрээнд "Ахмадын", "Эмэгтэйчүүдийн", "Залуучуудын" талаарх тусгайлсан хөтөлбөрийг төр олон нийтийн оролцоотойгоор шинэчлэн боловсруулж төрийн бодлогын үндэс болгоно.

Сонгогч Та бүхэн надад итгэл хүлээлгэж мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх боломж олговол Монгол орон хөгжлийн зам дээр шуударч хүчээ зангидан зүтгэх шинэ цагийн сэжүүр ургах болно.

Мөнх тэнгэрийн хүчин дор хөгжин дэвшиж

Монгол түмэн жаргах болтугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИД АРДЧИЛСАН
НАМААС НЭР ДЭВШИГЧ УЛАМОРГИХ ОВГИЙН
РАДНААСҮМБЭРЭЛИЙН ГОНЧИГДОРЖ**

*ХҮП жарны "Сүргийн манлай" хэмээх төмөр могой
жилийн хэргэмийн дээр*